



ҮЕР, УСНЫ ОСЛООС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НЭГДСЭН
АРГА ХЭМЖЭЭНИЙ УДИРДАМЖ

Нэг. Зорилго

1.1 Сүүлийн 5 жилийн улсын хэмжээний статистик мэдээгээр усны ослоор нийт 472 хүн амь насаа алдсаны 369 буюу 78.0 хувь нь том хүн, 103 буюу 22.0 хувь нь хүүхэд байна. Усны ослоор амь насаа алдагсдын шалтгаан нөхцөлийг судлан үзэхэд амралт зугаалгаар явж гол, нуурын усанд орох үедээ архи дан согтуурсан, малчид үертэй болон ус ихтэй үед гарамгүй газраар гол гатлахаар явсан, хүүхдийг хараа хяналтгүй орхисон зэрэг шалтгаан 70 хувийг эзэлж байна.

1.2. Иймд иргэд, олон нийтэд мэдээлэл, сурталчилгааг шат дараатай зохион байгуулж, сэрэмжлүүлэх ажлыг эрчимжүүлэх, бага насны хүүхдэд тавих хараа хяналтаа сайжруулж, усанд осолдохоос урьдчилан сэргийлэх, мэргэжлийн байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх, үер, усны ослын тоо, хохирлыг бууруулахад чиглэгдэнэ.

Хоёр. Хугацаа, хамрах хүрээ

2.1. 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс 09 дүгээр сарын 15-ны өдрийн хооронд зохион байгуулна.

2.2. Аймаг, сум, нийслэл, дүүрэг, баг, хорооны айл өрх, иргэд, олон нийт, хүүхдүүдэд чиглэгдэнэ.

Гурав. Зохион байгуулалт

3.1. Бүс, орон нутгийн онцлогт тохируулан хэрэгжүүлэх ажлын удирдамжийг боловсруулан, аймаг, нийслэлийн Засаг даргаар батлуулан, хэрэгжилтийг хангуулна.

3.2. Нутгийн захиргааны болон мэргэжлийн байгууллагатай хамтран үерийн хамгаалалтын болон ус зайлуулах инженерийн байгууламжид үзлэг, шалгалт зохион байгуулах, цэвэрлүүлсэн эсэхэд хяналт тавина.

3.3. Үер, усны ослын урьдчилан сэргийлэх мэдээ, сэрэмжлүүлэг, шторкийг иргэд олон нийтэд, төв, орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, цахим орчин /facebook, Instagram, twitter/-д сурталчилна.

3.3. Үер, усны ослоос урьдчилан сэргийлэх ухуулга, сурталчилгааны материалыг бэлтгэн, хэвлүүлж, өртөх эрсдэл бүхий айл өрхийн судалгааг гаргах, хүргүүлж ажиллана.

3.4. Сургууль, Цэцэрлэг, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн ажилтан, алба хаагч нарт усны ослоос урьдчилан сэргийлэх, анхаарах асуудлын чиглэлээр сургалтыг үе шаттайгаар зохион байгуулна.

3.5. Усны осол ихээр тохиолддог байршлыг тодорхойлж, тухайн байршлуудад эргүүл, хяналтыг тогтмолжуулна.

3.6. Гол, мөрөн, нуур, цөөрөм дагуу Цагдаагийн байгууллага, Боловсролын байгууллага, Хүүхдийн байгууллага, Хүүхэд хамгааллын байгууллага, Монголын Улаан загалмай нийгэмлэгийн дунд шатны хороотой хамтран хөдөлгөөнт эргүүл ажиллуулах, амарч, зугаалж буй иргэдэд сэрэмжлүүлэг, мэдээлэл өгнө.

3.7. Уул уурхай, ашигт малтмал, барилгын салбарын болон бусад төрлийн олборлох үйл ажиллагаанаас үүссэн усан сан, тогтоол ус, усны осол гарч болзошгүй газруудад мэргэжлийн байгууллагатай хамтран хяналт шалгалт зохион байгуулж, зөрчил дутагдлыг арилгуулах, болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулалтын холбогдох арга хэмжээ авна.

3.8. Үерийн эрсдэлтэй бүсэд суурьшсан айл өрхийн судалгааг гарган, нүүн шилжих тухай шаардах хуудсыг тухай бүр хүргүүлж, шаардлагатай тохиолдолд нүүлгэн шилжүүлэх ажлыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газартай хамтран зохион байгуулна.

3.9. Ахуйн зориулалттай шаардлага хангахгүй хийлдэг завь, гудас, хөвөгчийг гол, нуурын усанд ашиглахгүй байх талаар иргэд, олон нийтэд анхааруулга санамж өгнө.

3.10. Онцгой байдлын ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх газраас удирдамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжлийн нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллана

Дөрөв. Нэгдсэн арга хэмжээний зардал, үр дүн

4.1. Онцгой байдлын ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх газраас удирдамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжлийн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллана.

4.2. Нэгдсэн арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах зардлыг Гамшгаас хамгаалах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.1, 31.1.3-т заасны дагуу шийдвэрлүүлэх, түүнчлэн Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн үйл ажиллагааны зардал болон төсөл хөтөлбөр, олон улсын байгууллагаас санхүүжүүлнэ.

4.3. Төв, орон нутгийн хэмжээнд зохион байгуулсан арга хэмжээний үр дүнг 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор, Онцгой байдлын ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх газарт uugankhuu@nema.gov.mn цахим хаягаар баталгаажсан тайлан, шалгуур үзүүлэлтийн хүснэгтийн хамт сканердан (файлаар, зурган тайлан) ирүүлнэ.

4.4. Улсын хэмжээнд зохион байгуулсан нэгдсэн арга хэмжээний үр дүнг Урьдчилан сэргийлэх газар нэгтгэн дүгнэж, Онцгой байдлын ерөнхий газрын даргад танилцуулж, Монгол Улсын Шадар сайдын ажлын албанд 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор хүргүүлнэ.

---o0o---